

“ХАЙ БИ ОЙЛ”

Хувьцаат Компани

2022 оны 12 сарын 31-ний өдрөөр
тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАН



Агууллага

	Хуудас
Байгууллагын мэдээлэл	2
Хараат бус аудиторын дүгнэлт	3-4
Санхүүгийн тайлан	5-8
Санхүү байдлын тайлан	5
Орлогын дэлгэрэнгүй тайлан	6
Өмчийн өөрчлөлтийн тайлан	7
Мөнгөн гүйлгээний тайлан	8
Санхүүгийн тайлангийн тэмдэглэл	9-27

“ХАЙ БИ ОЙЛ” Хувьцаат компани

Байгууллагын мэдээлэл

Үүсгэн байгуулах шийдвэр	“ХАЙ БИ ОЙЛ” ХК нь 2007 оны 06 сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын №41 тоот тогтоолын дагуу хувьцаат компанийн хэлбэрээр дахин зохион байгуулагдсан	
Үндсэн үйл ажиллагаа	Техникийн хаягдал тосыг үйлдвэрийн аргаар боловсруулан мазут үйлдвэрлэх, худалдах	
Гэрчилгээ ба тусгай зөвшөөрөл	“Хай Би Ойл” ХК нь 2007 оны 12 сарын 27-ны өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлж 2615134 тоот регистрийн дугаар бүхий, Улсын бүртгэлийн 9010001063 тоот гэрчилгээ авсан.	
Хувь нийлүүлэгчид	Нью Альфа ХХК	33%
	Кибер циркл ХХК	32%
	Би Ди Сек ҮЦК	16%
	Монгол алтан минт ХХК	8%
	GFSelect Equity Fund	3%
	Бусад жижиг хувьцаа эзэмшигчид	6%
	Хай Би Ойл ХК (халаасны хувьцаа)	2%
Төлөөлөн удирдах зөвлөл	Б.Пүрэвбаатар	ТУЗ-ийн дарга
	Р.Оюунбат	ТУЗ-ийн хараат гишүүн
	С.Одгэрэл	ТУЗ-ийн хараат гишүүн
	Ц.Батбаяр	ТУЗ-ийн хараат гишүүн
	Б.Лхагвадорж	ТУЗ-ийн хараат гишүүн
	А.Батбаяр	ТУЗ-ийн хараат гишүүн
	Т.Тамир	ТУЗ-ийн хараат бус гишүүн
	А.Харцага	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Гүйцэтгэх Удирдлага	Ш.Амар-Отгон	Гүйцэтгэх Захирал
	Б.Бадамханд	Ерөнхий нягтлан бодогч
Байнгын хаяг	“Хай Би Ойл” ХХК Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, Сонсголонгийн /18135/-110	
Аудитор	“ЭВИДЕНСЕ Аудит” ХХК Сүхбаатар дүүрэг 9-р хороо Алтайн гудамж, Хойморь оффис, 502 тоот, Улаанбаатар хот, Монгол Улс	



“ЭВИДЕНС-АУДИТ”ХХК

Аудит, аутсорсинг

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
9-р хороо, 7-р хороолол, Алтайн гудамж, 281,
Хойморь оффис, 502 тоот, Регистр № 5211875,
Утас, факс: 976-7000-7121

E-mail: info@evidenceaudit.mn

Огноо: 2023 оны 03 сарын 13 № 06/2023

ХАЙ БИ ОЙЛ ХК УДИРДЛАГАД

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Аудиторын дүгнэлт

Бид “ХАЙ БИ ОЙЛ” ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болсон жилийн Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв бөгөөд шударгаар илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт /АОУС/-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад *Аудиторын хүлээх үүрэг хариуцлага* хэсэгт тайлбарласан. Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл /НБЭЗОУСЗ/-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм, Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу бид үйлчлүүлэгч компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЭЗОУСЗ -өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг хариуцлага болно. Энэхүү үүрэг хариуцлагад санхүүгийн тайлангуудыг заль мэх юмуу алдаанаас үүдэлтэй буруу илэрхийлэлээс ангид бэлтгэж шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтын системийг тогтоож ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож хэрэглэх, нөхцөл байдалд тохируулан нягтлан бодох бүртгэлийн тооцоолуудыг хийх зэрэг зүйлс багтана.

Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бид гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах үүрэгтэй. Бид аудитаа Нягтлан Бодогчдын Олон Улсын Холбооноос батлан гаргасан Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаарх зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, ёс зүйн шаардлагуудыг баримтлан гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажил нь санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгын үндэслэлийг тестийн үндсэн дээр шалгаж батлах ажлыг багтаадаг. Санхүүгийн тайлангууд нь алдаа эсвэл залилангийн улмаас гарч болох материаллаг буруу тайлагналтай байж болох эрсдэлийг үнэлэх зэрэг горимуудыг аудитор өөрийн шийдлээр сонгож авна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээг байгууллагын дотоод хяналтын системийн үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиохын тулд санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв танилцуулахтай холбоотой дотоод хяналтыг аудитор авч үздэг. Түүнчлэн аудитын ажил нь санхүүгийн тайланг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн тооцоолууд, хэрэглэсэн бүртгэлийн зарчмуудыг шалгах ажлыг өөртөө агуулдаг.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайлан нь монгол улсын Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно.



"Эвиденс Аудит" ХХК
Аудитор С.Бадамгарав
Улаанбаатар хот, Монгол Улс
Тусгай зөвшөөрөл: 090-2010

Огноо: 2022.03.13

“ХАЙ БИ ОЙЛ” ХК

2022 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн
САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Үзүүлэлт	Тод	2021.12.31	2022.12.31 (төгрөгөөр)
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	11	11,187,558	165,497,902
Дансны авлага	12	123,664,650	229,292,950
Татварын авлага	13	25,067,483	4,821,385
Бусад авлага	14	2,227,165,874	1,410,620
Бараа материал	15	111,522,620	21,670,469
Урьдчилж гарсан зардал	16	277,836	1,486,446
Эргэлтийн хөрөнгийн дүн		2,498,886,022	424,179,772
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	17	1,124,328,849	1,049,195,836
Биет бус хөрөнгө		869,916,700	869,916,700
Урт хугацаат хөрөнгө оруулалт	18	-	2,282,879,519
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		1,994,245,549	4,201,992,055
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		4,493,131,571	4,626,171,827
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
Өр төлбөр			
Богино хугацаат өр төлбөр	19		
Дансны өглөг		56,976,000	68,892,000
Татварын өр		8,341,513	20,047,778
Бусад богино хугацаат өр төлбөр		93,723,226	95,623,226
Богино хугацаат өр төлбөрийн дүн		159,040,739	184,563,004
Урт хугацаат өр			
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат өр төлбөрийн дүн		-	-
Өр төлбөрийн нийт дүн		159,040,739	184,563,004
Эздийн өмч			
Өмч: /хувийн/	22	5,211,895,400	5,211,895,400
Халаасны хувьцаа	23	(54,281,480)	(54,281,480)
Нэмж төлөгдсөн капитал		4,592,503,138	4,592,503,138
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	24	1,108,461,116	1,108,461,116
Хуримтлагдсан ашиг		(6,524,487,342)	(6,416,969,351)
Эздийн өмчийн дүн		4,334,090,832	4,441,608,823
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		4,493,131,571	4,626,171,827

“ХАЙ БИ ОЙЛ” ХК

2022 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

				(төгрөгөөр)	
Үзүүлэлт	Тод	2021.12.31	2022.12.31		
Борлуулалтын орлого	1	133,363,036	744,226,510		
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	2	(82,967,220)	(185,076,100)		
Нийт ашиг (алдагдал)		50,395,816	559,150,410		
Хүүний орлого	3	151,532	348,791		
Түрээсийн орлого	4	-	10,145,455		
Бусад орлого	5	2,364,165	52,231,437		
Ерөнхий ба удирдлагын зардал	6	(310,202,289)	(469,106,119)		
Бусад зардал	7	(480,000)	(1,984,134)		
Гадаад валютын ханшийн зөрүүний олз/ (гарз)	8	(105,187)	(6,442,903)		
Үндсэн хөрөнгө данснаас хассаны ол/(гарз)	9	-	(3,582,453)		
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		(257,875,963)	140,760,483		
Орлогын татварын зардал		(15,153)	(14,918,752)		
Татварын дараах ашиг (алдагдал)		(257,891,116)	125,841,731		
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(257,891,116)	125,841,731		

“ХАЙ БИ ОЙЛ” ХК

2022 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020.12.31	5,211,895,400	(54,281,480)	4,592,503,138	1,108,461,116	(6,261,272,109)	4,597,306,065
Өмчид гарсан өөрчлөлт					(5,324,118)	(5,324,118)
Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал					(257,891,116)	(257,891,116)
2021.12.31	5,211,895,400	(54,281,480)	4,592,503,138	1,108,461,116	(6,524,487,343)	4,334,090,831
Өмчид гарсан өөрчлөлт					-	-
Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал					125,841,731	125,841,731
Бусад дэлгэрэнгүй орлого					(18,323,720)	(18,323,720)
2022.12.31	5,211,895,400	(54,281,480)	4,592,503,138	1,108,461,116	(6,416,969,332)	4,441,608,843

• ЗЭВЦЭГЭСЭ АУДИТ • ХХК
18,323,720

Хавсаруулсан тэмдэглэлүүд нь эдгээр сангуусгийн тайлангийн салшгүй хэсэг болно



“ХАЙ БИ ОЙЛ” ХК

2022 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилийн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	(төгрөгөөр) 2021.12.31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
Мөнгөн орлогын дүн (+)	134,811,909
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	134,675,108
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	48,798
Бусад мөнгөн орлого	88,003
Мөнгөн зарлагын дүн (-)	274,066,859
Ажилчдад төлсөн мөнгө	143,471,868
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	39,655,947
Бараа материал худалдан авахад төлсөн	17,083,880
Ашиглалтын зардал төлсөн	3,364,067
Түлш шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн	20,072,328
Татварын байгууллагад төлсөн	23,618,079
Даатгалын төлбөрт төлсөн	810,985
Бусад мөнгөн зарлага	25,989,704
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(139,254,950)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-
Мөнгөн орлогын дүн (+)	79,280,148
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	79,280,148
Мөнгөн зарлагын дүн (-)	19,098,536
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	154,536
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	18,944,000
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	60,181,611
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-
Мөнгөн орлогын дүн (+)	67,199,669
Зээл авсан өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	67,170,000
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	29,669
Мөнгөн зарлагын дүн (-)	12,630,477
Зээл өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	12,619,700
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	10,777
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн дүн	54,569,191
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(24,504,148)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(24,504,148)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	35,697,706
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,187,558

“ХАЙ БИ ОЙЛ” ХК

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ

1. ТАЙЛАГНАГЧ АЖ АХУЙН НЭГЖ

“ХАЙ БИ ОЙЛ” ХК нь 2007 оны 06 сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын №41 тоот тогтоолын дагуу хувьцаат компанийн хэлбэрээр дахин зохион байгуулагдсан

Техникийн хаягдал тосыг үйлдвэрийн аргаар боловсруулан мазут үйлдвэрлэх, худалдах

“Хай Би Ойл” ХК нь 2007 оны 12 сарын 27-ны өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлж 2615134 тоот регистрийн дугаар бүхий, Улсын бүртгэлийн 9010001063 тоот гэрчилгээ авсан.

“ХАЙ БИ ОЙЛ” ХК

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

2. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ

Эдгээр санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Хороо (“НББОУСХ”) ноос гаргаж, мөрдүүлсэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”) болон НББОУСХ-ны Тайлбарын Байнгын Хорооноос гаргасан тайлбарын дагуу бэлтгэгдсэн байна.

Эдгээр санхүүгийн тайлангууд нь түүхэн өртөгт суурилан бэлтгэгдсэн.

Компанийн үйл ажиллагааны болоод тайлагнагч валют нь Монгол улсын Төгрөг болно. Эдгээр санхүүгийн тайлангууд нь төгрөгөөр илэрхийлэгдсэн бөгөөд мянган төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнагдсан.

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэх нь удирдлагаас нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол хийх болон нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэхтэй холбоотой мэргэжлийн шийдлүүдийг хийхийг шаарддаг.

Өөдрөг төсөөлөл

Санхүүгийн тайлангууд нь Компани тасралтгүй үйл ажиллагаа явуулна гэсэн өөдрөг төсөөлөлд суурилан бэлтгэгдсэн. 2022 оны 12 сарын 31-ний байдлаар компанийн эргэлтийн хөрөнгө нь эргэлтийн өр төлбөрөөс 216,665,091 төгрөгөөр (2021 онд 2,227,041,454.67) давсан байна. Эргэлтийн хөрөнгө, өр төлбөрийн талаар Тэмдэглэл 4-д толилуулсан.

“ХАЙ БИ ОЙЛ” ХК

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ

3.1 Гадаад валютаарх ажил гүйлгээ

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөөрх хөрөнгө, өр төлбөрийг тайлагнах валют (Төгрөг) руу хөрвүүлэхдээ балансын өдрийн албан ханшаар, гадаад валютаар илэрхийлэгдсэн орлого, зарлагуудыг гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлсэн. Эдгээр хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүний олз ба гарзыг орлогын тайланд тусгасан.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг түүхэн өртгөөр нь илэрхийлж гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлсэн.

3.2 Өмч, Барилга, Тоног төхөөрөмж

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Өмч, барилга, тоног төхөөрөмжийн өртөг нь худалдан авсан үнэ, импортын татвар, эргэн төлөгдөхгүй худалдан авалтын татвар болон тухайн хөрөнгийг зориулалтын ажлын байршил, нөхцөлд бэлэн болгохтой холбогдсон бусад зардал зэргээс бүрдэнэ. Үл хөдлөх хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсний дараа үеэс анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр нь бүртгэнэ.

Хэрэв тухайн хөрөнгийн гол эд ангийн ашиглах хугацаа ялгаатай байгаа тохиолдолд тэдгээрийг салгаж тусад нь ангилдаг.

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг борлуулснаас үүссэн олз ба гарзыг борлуулж буй үнэ болон тухайн хөрөнгийн дансны үнэтэй харьцуулж тодорхойлдог бөгөөд цэвэр дүнгээр орлогын тайланд “бусад олз/гарз”-аар хүлээн зөвшөөрдөг.

Дараа үеийн зардал

Өмч, барилга, тоног төхөөрөмжийн эд ангийг дахин солих, орлуулахтай холбоотой өртгийг уг эд анги ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөх болон өртгийг найдвартай хэмжих боломжтой үед хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө. Солигдсон эд ангийн дансны үнээр хөрөнгийн дансны үнийг бууруулна.

Өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн зардал гарсан тайлант үеийн орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

Элэгдэл

Элэгдлийг өмч, барилга, тоног төхөөрөмжийн ашиглагдах хугацаагаар нь шулуун шугамын аргаар байгуулж орлого үр дүнгийн дэлгэрэнгүй тайланд тусгана. Өмч, барилга, тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар тогтоосон хугацаа нь дараах байдалтай байна:

“ХАЙ БИ ОЙЛ” ХК

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

▪ Барилга	40 жил
▪ Конторын тавилга эд хогшил	5-10 жил
▪ Тоног төхөөрөмж	10-15 жил
▪ Компьютер тооцоолох хэрэгсэл	3 жил
▪ Тээврийн хэрэгсэл	10 жил

Элэгдүүлэлтийн арга, ашиглах хугацаа, үлдэх өртгийг тайлагнах үе бүрд дахин тооцож үзнэ.

3.3 Үл хөдлөх хөрөнгийн сайжруулалт

Үл хөдлөх хөрөнгө сайжруулалтын зардалд тухайн сайжруулалт хийхэд шууд хуваарилагдах зардал мөн уг үйл ажиллагаанд үндэслэлтэй хуваарилагдаж болох бүх зардлыг хамааруулна.

Үл хөдлөх хөрөнгө сайжруулалтын зардлыг тайлант үеийн зардлаар бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө.

Зээлийн хүүгийн зардлыг тэмдэглэл 3.18-д дурдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу капиталжуулсан.

3.4 Биет бус хөрөнгө

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Биет бус хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан хорогдуулга болон хуримтлагдсан үнэгүйдлийн алдагдалыг хассан дүнгээр нь тусгадаг. Биет бус хөрөнгийг ашиглахаа больсон үед холбогдох гарзыг орлогын тайланд хүлээн зөвшөөрч данснаас хасдаг.

Хорогдуулга

Биет бус хөрөнгийг ашиглах боломжтой болсон өдрөөс эхлэн хорогдуулна. Биет бус хөрөнгийн хорогдуулалтыг тооцоолсон ашиглагдах хугацаагаар нь шулуун шугамын аргаар хорогдуулан орлого, үр дүнгийн тайланд тусгана.

3.5 Бараа материал

Бараа материалыг өртөг, цэвэр боломжит үнийн аль багаар нь тусгана. Бараа материалын өртгийг жигнэсэн дундаж өртгийн аргаар тодорхойлох бөгөөд худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байрлал, нөхцөлд авч ирэх хүртэлх зардлыг өртөгт шингээнэ.

3.6 Худалдааны болон бусад авлага

Бэлэн мөнгө хүлээн авах гэрээт эрх үүсэх буюу өөр нэг аж ахуйн нэгжээс санхүүгийн хөрөнгийг авах эрх үүссэн тохиолдолд дансны болон бусад авлагуудыг эхэндээ өртгөөр нь бүртгэдэг. Дансны авлага найдваргүй болсон үед шууд арга ашиглан данснаас хасдаг.

“ХАЙ БИ ОЙЛ” ХК

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

3.7 Үйлчлүүлэгчээс нэхэмжлэх дүн

Үйлчлүүлэгчээс нэхэмжлэх дүн нь хараахан нэхэмжлээгүй боловч тухайн өдрөөрх гэрээт ажлын гүйцэтгэл бөгөөд үйлчлүүлэгчээс авахаар хүлээгдэж буй нийт дүнг илэрхийлнэ. Энэ нь нийт гарсан зардал дээр нэмэх нь тухайн өдрөөрх хүлээн зөвшөөрөгдсөн ашиг, хасах нь гүйцэтгэлийн нэхэмжлэлүүд болон тухайн өдрөөрх хүлээн зөвшөөрөгдсөн алдагдал гэж хэмжигдэнэ. Нийт гарсан зардалд тухайн төсөлд шууд хамааралтай гарсан бүх зардал мөн үйл ажиллагааны хэвийн хүчин чадалд суурилан тооцож, хуваарилсан компанийн үйл ажиллагааны тогтмол ба хувьсах нэмэлт зардлуудыг багтаана.

Үйлчлүүлэгчээс нэхэмжлэх дүн нь балансад дансны болон бусад авлагын хэсэгт тайлагнагдана. Хэрэв харилцагчдаас хүлээн авсан төлбөр нь орлогын тайланд хүлээн зөвшөөрснөөс илүү байвал зөрүү нь үйлчлүүлэгчид өгөх өглөг болох ба балансад дансны болон бусад өглөг хэсэгт урьдчилж олсон орлогын адил тайлагнагдана.

3.8 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө болон банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгө (барьцаалсан хадгаламжийг оруулахгүй)-өөс бүрдэнэ.

3.9 Санхүүгийн хэрэгсэл

Санхүүгийн хэрэгслийн анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

НББОУС 39-д зааснаар санхүүгийн хэрэгсэл олз, гарзаар дамжин бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр, олгосон зээл ба авлага, авсан зээл ба өр, дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалт, борлуулах зориулалттай санхүүгийн хөрөнгө, хамгаалалтын зориулалттай үүсмэл санхүүгийн хэрэгсэл гэх мэтээр ангилагддаг.

Бүх санхүүгийн хэрэгслийг анх бодит үнэ цэнээр нь хэмжиж, хүлээн зөвшөөрдөг. Компанийн санхүүгийн хөрөнгө нь мөнгө, богино хугацаат хадгаламж, худалдааны ба бусад авлага, зээл ба бусад урьдчилгаа, урт хугацаат санхүүгийн авлага, бусад санхүүгийн хэрэгслийг агуулна.

Компанийн санхүүгийн өр төлбөр нь худалдааны ба худалдааны бус өглөг, банкны овердрафт, банкны зээл, санхүүгийн баталгааны гэрээ ба санхүүгийн үүсмэл хэрэгслүүдээс бүрдэнэ.

Санхүүгийн хэрэгслийн дараа үеийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Урт хугацаат санхүүгийн хэрэгсэлд тогтмол буюу тодорхойлогдох боломжтой төлбөр бүхий үүсмэл бус санхүүгийн хэрэгслүүд багтах бөгөөд анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш үр ашигт хүүгийн түвшний аргаар тооцсон хорогдуулсан өртгөөс үнийн бууралтыг хассан дүнгээр хэмжиж, хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хэрэгслийн хөнгөлөлт ба урамшууллыг тооцох замаар хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн аргаар тооцоолдог. Үр ашигт хүүгийн аргаар тооцоолсон урамшууллын хорогдуулалтыг орлогын тайланд санхүүгийн орлого ба зардлаар

“ХАЙ БИ ОЙЛ” ХК

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

тайлагнадаг. Үнийн бууралтаас үүдэлтэй гарзыг орлогын тайланд гарзаар хүлээн зөвшөөрдөг.

3.10 Үнийн бууралт

Үнийн бууралтыг илэрхийлсэн ямарваа нэг шинж тэмдэг байгаа эсэхийг тодорхойлохын тулд бараа материал, хойшлогдсон татварын хөрөнгөөс бусад хөрөнгийн дансны үнийг тайлант үеийн эцэс бүрд шалгадаг. Үнийн бууралтын ямар нэг шинж тэмдэг байгаа тохиолдолд хөрөнгийн эргэн нөхөгдөх дүнг тооцоолдог.

Хөрөнгийн нөхөгдөх үнэ буюу хөрөнгийн ашиг авчрах хэсэг нь түүний ашиглалтын үнэ ба бодит үнээс борлуулахтай холбоотой зардлыг хассан дүнгээс их байна. Ашиглалтын үнийг тогтоохдоо, хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн орлогыг тухайн хөрөнгийн эрсдэл, зах зээл дээрх мөнгөний үнэ цэнийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн түвшнээр хөнгөлж өнөөгийн үнэ цэнээр тогтооно. Хөрөнгийн үнийн бууралтыг шалгах зорилгоор хөрөнгүүдийг үргэлжилсэн хэрэглээнээс мөнгө бий болгогч хамгийн жижиг нэгжүүдээр бүлэглэх ба эдгээр мөнгө бий болгогч нэгжүүд нь бусад хөрөнгө болон бүлэг хөрөнгийн мөнгөн урсгалаас бүрэн хараат бус байна. Үнийн бууралтыг шалгах зорилгоор, бизнесийн нэгдэл дунд олж авсан гүүдвилийг хамтын ажиллагааны үр өгөөж гэж үзэн мөнгө үүсгэх нэгжид хуваарилдаг. Хөрөнгийн дансны үнэ эсвэл хөрөнгийн ашиг авчрах хэсэг нь эргэн нөхөгдөх дүнгээсээ давбал үнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрч, орлогын тайланд тусгадаг.

Гэхдээ хөрөнгийг дахин үнэлсэн дүнгээр тусгасан болон түүнд байгуулсан дахин үнэлгээний илүүдлээс үнийн бууралтын алдагдлын дүн хэтрээгүй байвал үнийн бууралтын алдагдлыг тусгадаггүй. Үнийн бууралтын алдагдлыг эхлээд мөнгө үүсгэх нэгжүүдэд хуваарилагдсан гүүдвилийн дансны үнийг багасгаж, дараа нь нэгж дэх бусад хөрөнгийн дансны үнийг хувь тэнцүүгээр бууруулах замаар бүртгэдэг.

Гүүдвилтэй холбоотой үнийн бууралтын алдагдлыг хүчингүй болгодоггүй. Бусад хөрөнгүүдийн хувьд өмнөх жилүүдэд үүссэн үнийн бууралтын алдагдлыг бууруулах эсвэл байхгүй болтол нь тайлант үе болгоноор үнэлдэг. Нөхөгдөх хэмжээг тодорхойлоход хэрэглэсэн тооцоонд өөрчлөлт гарсан үед үнийн бууралтаас үүсэх алдагдлыг хүчингүй болгодог. Хэрэв үнийн бууралтын алдагдал гараагүй үед хөрөнгийн тодорхойлсон дансны үнэ, элэгдэл, хорогдуулгыг хассан цэвэр дүнгээс хэтрэхээргүй байхаар үнийн бууралтыг буцааж хүчингүй болгодог.

3.11 Худалдааны болон бусад өглөг

Худалдааны болон бусад өглөгүүдийг өртгөөр нь хэмждэг. Бэлэн мөнгө өгөх гэрээт эрх үүсэх буюу өөр аж ахуйн нэгжид санхүүгийн хөрөнгийг хүргэх эрх үүссэн тохиолдолд өглогийг хүлээн зөвшөөрнө. Хувьцаат капитал

Энгийн хувьцаа

Энгийн хувьцааг эзэмшигчдийн өмчид ангилдаг. Энгийн хувьцаа ба хувьцааны опционыг гаргахад шууд хуваарилагдах нэмэгдэл өртгийг аливаа татварын нөлөөг хассан цэвэр дүнгээр нь өмчийг бууруулан хүлээн зөвшөөрнө.

“ХАЙ БИ ОЙЛ” ХК

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

Нэмж төлөгдсөн капитал

Компани өөрийн хувьцааг нэрлэсэн үнээс давсан үнээр худалдан борлуулснаас үүссэн зөрүүг нэмж төлөгдсөн капитал хэмээн өмчөөр хүлээн зөвшөөрдөг.

3.12 Ноогдол ашиг

Ноогдол ашгийг бодитойгоор хуваарилсан үедээ хуримтлагдсан ашгийг бууруулан тайлагнадаг.

3.13 Орлого хүлээн зөвшөөрөлт

Үйлчилгээний орлого

Үйлчилгээний орлогыг үйлчилгээ үзүүлсэн тухайн тайлант хугацаанд нь хүлээн зөвшөөрдөг. Дараах нөхцөлүүд хангагдсан тохиолдолд үйлчилгээний орлогыг хүлээн зөвшөөрдөг. Үүнд:

- (a) Орлогын дүнг найдвартай хэмжиж болохоор байх;
- (b) ажил гүйлгээний урсгал нь компанид эдийн засгийн өгөөж өгөх магадлалтай байх;
- (c) тайлант хугацааны эцэст ажил гүйлгээний иж бүрдлийн үе шатыг тооцож болохоор байх
- (d) тухайн ажил гүйлгээтэй холбогдон гарсан зардал болон уг ажил гүйлгээг гүйцээх өртгийг найдвартай тодорхойлж болохоор байх

Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой ажил гүйлгээний үр дүнг найдвартай үнэлж болохооргүй байвал нөхөгдөх боломжтой зардлын хэмжээгээр орлогыг хүлээн зөвшөөрнө.

3.14 Өртөг/Зардал хүлээн зөвшөөрөлт

Тайлант хугацаанд хувь нийлүүлэгчдэд хуваарилснаас бусад шалтгааны улмаас мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөрийг ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг.

Борлуулалт ба ерөнхий үйл ажиллагааны зардал

Борлуулалт ба ерөнхий үйл ажиллагааны зардлыг мөнгөөр төлөгдсөнөөс нь үл хамаарч гарсан тухайн тайлант хугацаанд нь зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

3.15 Санхүүгийн орлого/зардал

Санхүүгийн орлогод хөрөнгө оруулалтал бологдсон хүүгийн орлогыг хамааруулна. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн орлого олсон тайлант үеийнх нь орлогын тайланд тусгана.

Санхүүгийн зардалд зээлийн хүүгийн зардал хамааруулна. Капиталжуулах шаардлагыг хангасан хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай капиталжуулагдсан зээлийн өртгөөс бусад бүх зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн гарсан тайлант үеийнх нь орлогын тайланд тусгана.

“ХАЙ БИ ОЙЛ” ХК

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

Барьж босгоход хугацаа шаардлагатай хөрөнгийн өртөгт багтаж байгаа зээлийн өртгийг тухайн хөрөнгийг ашиглахад бэлтгэх юмуу борлуулах үйл явцад шаардагдах үйл ажиллагаанаас гарч буй зардал, зээлийн өртөг нь бий болсон үеэс эхлэн капиталжуулдаг.

3.16 Зээлийн өртөг

Бэлтгэл шаардагдах хөрөнгийг худалдан авах, барих, үйлдвэрлэхтэй шууд холбоотой гарсан зээлийн зардлыг (зээлийн хүүг агуулсан) тухайн хөрөнгийн өртгийн нэг хэсэг болгон капиталжуулдаг.

Харин энэхүү зээлийн өртгийн капиталжуулалтыг тухайн хөрөнгийг барьж босгох үйл явц зогссон юмуу бүрэн дууссан үед зогсоодог.

3.17 Татварын зардал

Татварын зардал нь тайлант жилийн болон хойшлуулсан татварын зардлын нийлбэрээс бүрдэх бөгөөд орлогын тайланд тусгагддаг. Компанийн татвар нь тайлант жилийн татвар ногдуулах орлогод ногдох балансын өдрөөр хүчинтэй байгаа татварын хувь хэмжээгээр тооцсон бөгөөд өмнөх үеийн татварын өглөг, хойшлуулсан татвар хөрөнгө ба өр төлбөрийг тохируулсан хүлээгдэж буй татварын хөрөнгө эсвэл өглөг юм.

Хойшлогдсон татвар нь санхүүгийн тайлагналын зорилгоор бүртгэсэн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ ба татварын тайлагналын зорилгоор бүртгэсэн үнийн зөрүүнээс үүссэн түр зөрүү юм. Хойшлогдсон татварыг тайлагнах өдрөөрх болон цаашид хэрэгжих хуульд үндэслэн буцаалт хийгдэх түр зөрүүнд хэрэгжихээр хүлээгдэж байгаа татварын хувиар тооцдог. Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг татвар ногдуулах нэг аж ахуйн нэгжид хамаарах татварын байгууллагаас тогтоосон тайлант үеийн татвар ногдуулах хөрөнгө, өр төлбөрийн эсрэг хуулийн эрх үүргийн дагуу хооронд нь хааж болох бөгөөд гэхдээ эдгээр татвар ногдуулах хөрөнгө, өр төлбөр нь цэвэр дүнд суурилсан байх хэрэгтэй.

Ирээдүйн татвар ногдуулах ашиг нь татварын түр зөрүүг нөхөхүйц байх тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант үе бүрд хянаж холбогдох татварын өгөөжийг хэрэгжүүлэх буюу бууруулдаг.

3.18 Ажилчдын тэтгэмж

Тур хугацааны ажилчдын тэтгэмж

Богино хугацаат ажилчдын тэтгэмж нь хөнгөлөлтгүй сууриар хэмжигддэг бөгөөд ажилчдын ажил гүйцэтгэсэн тайлант үед нь зардлаар бүртгэдэг.

Хэрэв ажилчдын гүйцэтгэсэн ажлын үр дүнгээс үүдэн компани хуулийн дагуу урамшуулал өгөх хариуцлага хүлээх болон урамшууллын дүнг үндэслэлтэй тооцоолох боломжтой үед тооцоолсон дүнгээр богино хугацаат урамшууллын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

“ХАЙ БИ ОЙЛ” ХК

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал

Монгол улсын хуулийн дагуу Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа компаниуд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ёстой бөгөөд уг зардлыг гарсан тухайн үед нь орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

1. САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ-ЭРСДЛИЙН УДИРДЛАГА

Компанийн үйл ажиллагаа нь дараах санхүүгийн эрсдлүүдэд өртөж болно:

- Зээлийн эрсдэл (Credit risk)
- Хүүгийн түвшний эрсдэл
- Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн эрсдэл
- Хөрвөх чадварын эрсдэл

Компани нь бусад бизнесүүдийн нэгэн адил санхүүгийн хэрэглүүрийн хэрэглээнээс үүсэх эрсдлүүдтэй тулгардаг. Энэ тэмдэглэлд Компанийн эрсдлийн удирдлагын бодлого, энэхүү эрсдлийг зохицуулах процесс ба түүнийг хэмжих аргуудыг тайлбарлана. Эдгээр эрсдэлтэй холбоотой нэмэлт тоон мэдээллийг санхүүгийн тайланд зохих ёсоор тэмдэглэсэн.

Энэ тэмдэглэлд дурдаагүй л бол компанийн нүүрлэсэн санхүүгийн хэрэглүүрийн эрсдэл, түүнтэй холбоотой бодлого, эдгээр эрсдлийг зохицуулах процесс эсвэл түүнийг хэмжихэд хэрэглэгдсэн аргуудад ямар нэгэн томоохон өөрчлөлт ороогүй болно.

Компанид байгаа гол санхүүгийн хэрэгслүүд:

- Худалдааны ба бусад авлага
- Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс
- Худалдааны ба бусад өглөг
- Холбоотой талд өгөх өглөг
- Урт хугацаат зээл
- Урт хугацаат санхүүгийн түрээсийн өглөг

Санхүүгийн хэрэгслийн хураангуйг дор харуулав:

Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
Санхүүгийн хөрөнгө		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	165,497,902.21	11,187,558.49
Дансны авлага	229,292,950.00	123,664,650.00
Татвар, НДШ-ийн авлага	4,821,385.22	25,067,483.23
Бусад авлага	1,410,619.86	2,227,165,874.14
Урьдчилж гарсан зардал	1,486,445.64	277,835.89
Нийт санхүүгийн хөрөнгө	402,509,302.93	2,387,363,401.75
Санхүүгийн өр төлбөр		
Дансны өглөг	68,892,000.00	56,976,000.00
Татварын өр	20,047,777.88	8,341,513.08
Бусад богино хугацаат өр төлбөр	95,623,226	93,723,226
Нооц / өр төлбөр /	1,281,208	1,281,208
Нийт санхүүгийн өр төлбөр	185,844,211.88	160,321,947.08
Цэвэр санхүүгийн хөрөнгө/өр төлбөр	216,665,091.05	2,227,041,454.67

“ХАЙ БИ ОЙЛ” ХК

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

Ерөнхий бодлого ба процессууд

Удирдлага нь Компанийн эрсдлийн удирдлагын бодлогод гол үүрэг хариуцлага хүлээхийн хажуугаар түүнийг тодорхойлж бэлтгэх үүрэгтэй байдаг. Удирдлагын зүгээс бодлогын үр дүнтэй хэрэгжилтийг баталгах үүднээс боловсруулалт ба үйл ажиллагааны процессийн эрх мэдлийг Компанийн санхүүгийн функцэд хариуцуулсан. Удирдлага нь Компанийн Санхүүгийн захирлаас сар бүр тайлан хүлээн авдаг бөгөөд тэд ажиллаж буй процессын үр дүнтэй байдал ба тогтоосон бодлогын тохиромжтой байдлыг шалгадаг.

Удирдлагын гол зорилго нь Компанийн өрсөлдөх чадвар, уян хатан байдалд хэт нөлөөлөхгүйгээр эрсдлийг аль болох их бууруулах бодлого тогтоох явдал юм. Энэхүү бодлоготой холбоотой нэмэлт мэдээллийг доор үзүүлэв:

Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл гэдэг нь үйлчлүүдэгч эсвэл санхүүгийн хэрэглүүр дэх бизнесийн түнш нь гэрээгээр заасан өр төлбөр төлөх үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд Компанид санхүүгийн гарз үүсгэх эрсдэл юм. Компани нь ихэвчлэн зээлээр олгосон борлуулалтын улмаас зээлийн эрсдэлд өртдөг. Гэрээ байгуулахын өмнө шинэ үйлчлүүдэгчийн зээлийн эрсдлийг үнэлэх нь Компанийн гол бодлого байна.

Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл нь Компани хүүтэй, худалдагдах, гадаад валютаарх санхүүгийн хэрэглүүрийн хэрэглээнээс үүсдэг. Энэ нь санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн гүйлгээ нь хүүгийн хувь (хүүгийн хувийн эрсдэл), гадаад валютын түвшин (валютын эрсдэл) эсвэл зах зээлийн бусад хүчин зүйлс (бусад үнийн эрсдэл)-ийн улмаас хэлбэлзэх эрсдэл юм.

Хүүгийн түвшний эрсдэл

Хүүгийн түвшний эрсдэл гэдэг нь зах зээл дээрх зээлийн хүүгийн түвшний өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн гүйлгээ хэлбэлзэх эрсдэл юм.

Гадаад валютын эрсдэл

Компанийн Монгол улсын мөнгөн тэмдэгт (төгрөг)-өөс өөр валютаар хийж буй худалдан авалт болон төлбөрүүдэд гадаад валютын эрсдэл учирч байна. Эрсдэлд өртөж болох валют нь АНУ-ын ам.доллар болно. Гадаад валютын ханшийн хэт хэлбэлзэл нь тус компанийн санхүүгийн байдал, мөнгөн урсгалд нөлөөлөх магадлалтай.

Хөрвөх чадварын эрсдэл

Хөрвөх чадварын эрсдэл нь ажлын капитал, зээлийн хэрэглүүр дэх санхүүгийн төлбөр, үндсэн өрийг төлж барагдуулалтын Компанийн удирдлагаас үүсдэг. Энэ нь Компани нь санхүүгийн өр төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулахад хүндрэлтэй тулгарах эрсдэл юм.

Компанийн бодлого бол өр төлбөр төлөх хугацаа болоход хангалттай бэлэн мөнгөтэй байх явдал юм. Энэ зорилгод хүрэхийн тулд компани нь дор хаяж 45 хоногт хүлээгдэж

“ХАЙ БИ ОЙЛ” ХК

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

буй шаардлагыг биелүүлэхийн тулд тогтмол бэлэн мөнгөний үлдэгдэлтэй(эсвэл харилцан тохиролцсон хэрэглүүр) байх явдал юм.

Түргэн хөрвөх чадварын эрсдэл нь Компанийн мөнгөн урсгалыг удирдах чадвараас үүсдэг. Компани тухайн жилийн төсвийг мөнгөн урсгалын хэрэгцээ шаардлагыг үнэлсний үндсэн дээр бэлтгэдэг. Одоогийн байдлаар үйл ажиллагааны санхүүжилтийн хэрэгцээгээ толгой компаниас авсан зээлээр хангаж бай

“ХАЙ БИ ОЙЛ” ХК

2021 оны 12 дугаар сарын 31-ний

өдрөөр тасалбар болсон жилийн

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)**№1. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО**

<u>Үзүүлэлт</u>	<u>2021.12.31</u>	<u>2022.12.31</u>
Борлуулалт мазут	122,733,636	713,919,692
Үзүүлсэн ажил үйлчилгээний орлого	10,629,400	30,306,818
Борлуулалтын орлогын дүн	133,363,036	744,226,510

№2. БОРЛУУЛАЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

<u>Үзүүлэлт</u>	<u>2021.12.31</u>	<u>2022.12.31</u>
Борлуулсан бараа, бүтээгдэхүүний өртөг	82,967,220	185,076,100
Борлуулсан бүтээгдэхүүний өртгийн дүн	82,967,220	185,076,100

№3. ХҮҮНИЙ ОРЛОГО

Орлого үр дүнгийн тайланд тусгасан хүүгийн орлого нь дараах зүйлсээс бүрдэнэ.

<u>Үзүүлэлт</u>	<u>2021.12.31</u>	<u>2022.12.31</u>
Хүүний орлого	151,532	348,791
Хүүний орлогын дүн	151,532	348,791

“ХАЙ БИ ОЙЛ” ХК

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

№4. ТҮРЭЭСИЙН ОРЛОГО

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Хөрөнгө түрээслэсэн орлого	-	10,145,455
Бусад орлогын дүн	-	10,145,455

№5. БУСАД ОРЛОГО

Орлого үр дүнгийн тайланд тусгасан бусад орлого нь дараах зүйлсээс бүрдэнэ.

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Үйл ажиллагааны бус бусад орлого-Захиргаа	2,254,546	52,122,261
Үйл ажиллагааны бус бусад орлого-Үйлдвэр	109,619	109,176
Бусад орлогын дүн	2,364,165	52,231,437

№6. ЕРӨНХИЙ БА УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

Орлого үр дүнгийн тайланд тусгасан ерөнхий ба удирдлагын зардал нь дараах зүйлсээс бүрдэнэ.

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Цалин хөлс, шагнал	127,455,309	99,576,229
Нийгмийн даатгалын зардал	15,312,585	26,609,362
Урсгал засвар үйлчилгээний зардал	4,878,054	17,284,543
Түрээсийн зардал	602,000	1,500,000
Тээврийн зардал	-	109,091
Албан томилолтын зардал	13,006,102	64,945,348
Элэгдлийн зардал	100,927,223	103,215,470
Шатахууны зардал	5,696,990	9,671,348
Шуудан холбооны зардал	1,676,255	7,884,241
Сургалт семинар	650,000	-
Хангамжийн материалын зардал	547,656	864,000
Бичиг хэргийн зардал	539,783	167,127
Даатгалын төлбөрийн зардал	810,985	610,875
Ашиглалтын зардал	3,364,067	30,575,513
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс	-	10,802,000
Төсөвт төлсөн АТБӨЯТХ-ийн татвар	566,249	497,846
Байгалийн нөөц ашигласны татвар	524,122	1,928,543
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	6,203,872	3,125,895
Бусад зардал	27,441,037	89,738,687
310,202,289	469,106,119	

“ХАЙ БИ ОЙЛ” ХК**2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)****№7. БУСАД ЗАРДАЛ**

Орлого үр дүнгийн тайланд тусгасан бусад зардал нь дараах зүйлсээс бүрдэнэ.

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Үйл ажиллагааны бус бусад зардал-Захиргаа	200,000	1,145,043
Үйл ажиллагааны бус бусад зардал-Үйлдвэр	280,000	839,091
Зардлын дүн	480,000	1,984,134

№8. ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЗӨРҮҮНИЙ ОЛЗ (ГАРЗ)

Орлого үр дүнгийн тайланд тусгасан гадаад валютын ханшийн зөрүүний олз/ (гарз) нь дараах зүйлсээс бүрдэнэ.

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	26,541,991	129,620,229
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	26,647,178	136,063,132
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)-ын дүн	(105,187)	(6,442,903)

№9. ҮНДСЭН ХӨРӨНГӨ ДАНСНААС ХАССАНЫ ОЛЗ (ГАРЗ)

Орлого үр дүнгийн тайланд тусгасан биет бус хөрөнгө данснаас хассан олз/ (гарз) нь дараах зүйлсээс бүрдэнэ.

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Биет бус хөрөнгө данснаас хассан гарз	-	3,582,453
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)-ын дүн	-	3,582,453

“ХАЙ БИ ОЙЛ” ХК

**2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)**

№10. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ

2022 болон 2021 онуудад Компани нь Монгол Улсын Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татварын тухай хуулийн дагуу тайлант жилийн 3 тэрбум төгрөг хүртэлх татвар ногдуулах орлогоос 10%-иар, 3 тэрбум төгрөгөөс дээших татвар ногдуулах орлогын дүнд 25%-иар орлогын албан татвар ногдуулж, төлөх үүрэгтэй.

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Татвар төлөхийн өмнөх ашиг/ (алдагдал)	(257,875,963)	140,760,483
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал	480,000	1,984,134
Тусгай хувь хэмжээгээр татвар ногдуулах орлогын дүн	(151,532)	(348,791)
Тайлант үед үүссэн түр зөрүү	105,187	6,442,903
Нийт татвар ногдох орлого	(257,442,308)	148,838,730
Ногдуулсан татвар	-	14,883,873
Тусгайлсан хувь хэмжээгээр төлбөл зохих орлогын татвар	15,153	34,879
Нийт ногдуулсан ОАТ	15,153	14,918,752

№11. МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдлийг Санхүүгийн байдлын тайланд харуулсан ба энэ нь дараах хэсгүүдээс бүрдэнэ:

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Кассд байгаа мөнгө	378	56,964
Бэлэн мөнгөний үлдэгдэл	378	56,964
<i>Банкин дах төгрөгийн харилцах данс</i>		
ХХБ 405025812 (төгрөг)	10,765,664	164,972,294
ХХБ 405065707 /USD/	243,800	281,010
ХХБ 463009182 EURO	177,716	187,634
<i>Банкин дах харилцах дансдын үлдэгдэл</i>	11,187,180	165,440,938
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	11,187,558	165,497,902

“ХАЙ БИ ОЙЛ” ХК**2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)****№12. ДАНСНЫ АВЛАГА**

Санхүүгийн байдлын тайланд тусгасан дансны авлага нь дараах зүйлсээс бүрдэнэ.

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Дансны авлага	124,253,800	229,882,100
Найдваргүй авлагын хасагдуулга	(589,150)	(589,150)
Авлагын дүн	123,664,650	229,292,950

№13. ТАТВАРЫН АВЛАГА

Санхүүгийн байдлын тайланд тусгасан татварын авлага нь дараах зүйлсээс бүрдэнэ.

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
НӨАТ-ын авлага	4,755,338	2,882,992
ҮХХӨАТатварын авлага	19,350,901	1,027,181
ААНОАТ-ын авлага	961,244	911,211
Авлагын дүн	25,067,483	4,821,385

№14. БУСАД АВЛАГА

Санхүүгийн байдлын тайланд тусгасан бусад авлага нь дараах зүйлсээс бүрдэнэ.

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Бусад авлага	2,357,202,751	10,620
Дараа тайлангийн авлага	600,000	-
Бусад авлага USD	53,909,780	1,400,000
Найдваргүй авлагын хасагдуулга /бусад авлага/	(184,546,656)	-
Авлагын дүн	2,227,165,874	1,410,620

№15. БАРАА МАТЕРИАЛ

Санхүүгийн байдлын тайланд тусгасан бараа материал нь дараах зүйлсээс бүрдэнэ.

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Түүхий эд материал	68,122,092	187,158
Бэлэн бүтээгдэхүүн	43,310,528	21,393,311
Сав баглаа бодоолол	90,000	90,000
Бараа материалын дүн	111,522,620	21,670,469

“ХАЙ БИ ОЙЛ” ХК

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

№16. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ

Санхүүгийн байдлын тайланд тусгасан урьдчилж төлсөн зардал нь дараах зүйлсээс бүрдэнэ.

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Урьдчилж гарсан зардал	277,836	1,486,446
Урьдчилж төлсөн зардлын дүн	277,836	1,486,446

№17. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
<i>Ахсны өртөг</i>		
Барилга байгууламж	235,430,800	235,430,800
Тавилга эд хогшил	8,426,763	8,604,035
Машин, тоног төхөөрөмж	725,825,900	725,825,900
Тээврийн хэрэгсэл	181,010,000	201,850,000
Бусад үндсэн хөрөнгө	17,038,118	17,038,118
Зөөврийн байр, сууц	63,670,388	63,670,388
Компьютер дагалдах хэрэгсэл	8,434,770	11,922,406
Үндсэн хөрөнгийн дүн	1,239,836,739	1,264,341,648
<i>Хуримтлагдсан элэгдэл</i>		
Барилга байгууламж	(4,901,450)	(9,802,900)
Тавилга эд хогшил	(5,922,553)	(7,183,499)
Машин, тоног төхөөрөмж	(57,137,414)	(114,274,828)
Тээврийн хэрэгсэл	(30,615,591)	(57,773,184)
Бусад үндсэн хөрөнгө	(10,766,647)	(14,593,453)
Зөөврийн байр, сууц	(4,074,236)	(8,148,472)
Компьютер дагалдах хэрэгсэл	(2,089,999)	(3,369,477)
Үндсэн хөрөнгийн дүн	(115,507,890)	(215,145,812)
НИЙТ	1,124,328,849	1,049,195,836

№18. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Газар эзэмших эрх	869,916,700	869,916,700
Биет бус хөрөнгийн дүн	869,916,700	869,916,700

“ХАЙ БИ ОЙЛ” ХК**2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)****№19. УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**

Санхүүгийн байдлын тайланд тусгасан урт хугацаат хөрөнгө оруулалт нь дараах зүйлсээс бүрдэнэ.

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Урт хугацаат хувьцаагаархи хөрөнгө оруулалт	-	2,282,879,519
Урт хугацаат хөрөнгө оруулалтын дүн	-	2,282,879,519

Компани нь Санхүүгийн Зохицуулах хорооны 2022 оны 1 сарын 26-ны өдрийн 44 тоот тогтоолын дагуу "Шарын гол" ХК-ийн өрийг хувьцаагаар солих зорилгоор хаалттай хүрээнд нэмж гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 2,253,583 ширхэг хувьцааг нэмж бүртгүүлсэн бөгөөд энэхүү нэмж гаргасан хувьцааг 2022 оны 1-р сарын 31-ний өдрийн 01/45 тоот албан бичгийн дагуу "Хай Би Ойл" ХК-ийн шилжүүлэн 2022 оны 2 сарын 8-ны өдөр өмчлөх эрхийг баталгаажуулсан.

№20. ӨГЛӨГ

Санхүүгийн байдлын тайланд тусгасан өглөгийн үлдэгдэл нь дараах зүйлсээс бүрдэнэ.

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Дансны өглөг Доллар	56,976,000	68,892,000
Нийт төлбөрийн дүн	56,976,000	68,892,000

№21. ТАТВАРЫН ӨР

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
НӨАТ-ын өглөг	4,519,559	-
ХХОАТ-ын өглөг	3,616,801	4,583,307
ААНБОАТ-ын өглөг	15,153	14,883,871
Бусад татвар-Хяналт шалгалт Татварын өглөг	190,000	580,600
Татварын өглөгийн дүн	8,341,513	20,047,778

№22. БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Бусад богино хугацаат өглөг	93,723,226	95,623,226
Бусад богино хугацаат өр төлбөрийн дүн	93,723,226	95,623,226

“ХАЙ БИ ОЙЛ” ХК

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

№22. ХУВЬЦААТ КАПИТАЛ

	Гаргасан болон төлөгдсөн хувьцаат капитал			
	2021 он	2021 он	2022 он	2023 он
	Хувьцааны тоо ширхэг	Хувьцаат капитал Мян.төг	Хувьцааны тоо ширхэг	Хувьцаат капитал Мян.төг
Энгийн хувьцаа				
01 сарын 01	52,118,954	5,211,895	52,118,954	5,211,895
Тайлант жилд нэмж гаргасан хувьцаа	-	-	-	-
Тайлант жилд эргүүлэн татсан хувьцаа	-	-	-	-
12 сарын 31	52,118,954	5,211,895	52,118,954	5,211,895

23. ХАЛААСНЫ ХУВЬЦАА

Компани 2019 онд иргэн Ө.Хүдрнау 54,281,480 төгрөгийн авлагаа барагдуулах зорилгоор түүний эзэмшилд байсан 986,936 ширхэг хувьцааг тооцон авч халаасласан. Халаасласан үеийн нэгж өртөг 55 төгрөг болсон.

24. ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ

Компани нь 2020 оны 12 сарын 31-нээрхи бодит байгаа хөрөнгөө санхүүгийн тайлангийн зориулалтаар Финайлиа ХХК-иар үнэлүүлсэн. Анхны өртөг болон үнэлгээний үр дүнгийн зөрүүгээр хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл тайлагнасан.

БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Санхүүгийн тайлан бэлтгэсэн өдөр болон аудитын тайлангийн өдрийн хооронд тохиолдсон болон үйл ажиллагаанд нөлөөлөх томоохон өөрчлөлт, үйл явдал гараагүй.